БАТЛАВ

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН

ОРЛОГЧ К.БАХЫТЖАН

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ӨЛГИЙ СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГИЙН МЕНЕЖЕНТИЙГ САЙЖРУУЛАХ, НОГООН ТОХИЖИЛТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026.02.24 Баян-Өлгийн аймаг Өлгийн сум

Зорилго:

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын хуучин төвлөрсөн хогийн цэгийн нөхцөл байдлыг сайжруулж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлын тархалтыг зогсоох, ил шаталтыг бууруулах, өдөр тутам ирж байгаа хог хаягдлыг хүлээн авах шинэ талбайг бэлтгэх, шинээр төлөвлөгдсөн төвлөрсөн хогийн цэгийг байгуулахад энэхүү ажлын зорилго оршино

Хийгдэх ажлууд:

1. Өлгий сумын 6-р багийн нутаг дэвсгэрт орших 2.5га талбайд 212500м.куб хогоор бүрхэгдсэн 3-р талбайг /зураг заасан/ хөрсөөр хучиж, 3-р талбайн 3 байршилд метан хий зайлуулах хоолой суурьлуулна. Хий зайлуулах хоолойны гадаргуугаас ил гарсан хэсгийг хар шар өнгийн будгаар будна.
2. Зураг заасан 3-р талбайн хойд талд байрлах 4-р талбайд зургийн дагуу хог хаягдлаар далан барьж, хөрсөөр хучин нягтруулах ба уг талбайд өдөр тутам ирэх хог хаягдлыг дарж булшлах тэгшилж талбайг бэлтгэнэ. Зураг заасан 2 байршилд метан хий зайлуулах хоолойг суурьлуулна.
3. Метан хий зайлуулах хоолойг хаягдал гялгар уутаар хийсэн 1000см диаметртэй 700см өндөртэй хуванцар хоолойг давхарлан холбож бэлхлэх байдлаар хийх ба хуванцар хоолой нь хий зайлуулах сараалжин нүхтэй байна.
4. Шинээр бий болгосон 4-р талбай уруу орох нягтруулсан шороон замыг зураглалын дагуу хийнэ.
5. Бугат сумын 4-р багийн нутаг дэвсгэрт шинээр төлөвлөгдсөн төвлөрсөн хогийн цэгийн байршилд зургийн дагуу хог хаягдал хүлээн авах талбайн ухлаг хийж талбайг бэлтгэж, ухлагаас гарсан хөрсөөр зураг заасны дагуу далан барих ба хогийн цэгийг тойруулан зургийн дагуу үерийн ус зайлуулах суваг хийнэ.
6. Ухлагаас гарсан илүү шороог зураг заасан хучилтын шороо нөөцлөх талбай дээр эмх цэгцтэй тарпец хэлбэрээр овоолго үүсгэн бэлгэнэ. Уг шороо нь цаашид өдөр тутам ирсэн хог хаягдлыг хөрсөөр хучих үйл ажиллагаанд ашиглагдах юм.
7. Шинэ төвлөрсөн хогийн цэгийн эргэн тойронд нийт 1887 метр урт хамгаалалтын торон хашаа барихаар төлөвлөсөн ба энэхүү ажлын хүрээнд одоо байгаа 817 метр хашааг зөөж зураг заасан байршилд шилжүүлэн суурьлуулна.

8. Бугат сумын 4-р багийн нутаг дэвсгэрт шинээр төлөвлөгдсөн төвлөрсөн хогийн цэгийн байршилд зурагт заасны дагуу 9600 метр.кубын багтаамжтай бохир шингэн хүлээн авах талбайг бэлтгэнэ. Бохир шингэн хүлээн авах талбайн ул хэсгийг 20см зузаан шар шавраар нягтруулна. Ухлагаас гарах шороогоор бохир шингэн хүлээн авах цөөрмийг тойруулаад зурагт заасны дагуу далан барих ба үлдэгдэл шороог шороо нөцлөх талбайд зөөнө.

Ажлын даалгаварт дурдсан зураг нь “Арч партнерс” ХХК-ийн зурсан “Баян-Өлгий аймгийн Өлгий сумын хог хаягдлын төвлөрсөн хогийн цэгийн менежентийг сайжруулах, ногоон тохижилт хийх төсөл” нэртэй, ШИФР: АР-26/01 дугаартай ажлын зураг төсөл байна.

Одоогийн нөхцөл байдал ба зураглал:

Зураг 01.Хуучин төвлөрсөн хогийн цэгийн 3-р талбайн харагдах

Зураг 02.Шинэ төвлөрсөн хогийн цэгийн харагдах байдал, баруунаас зүүн чиглэлд

Зураг 03. Шинэ төвлөрсөн хогийн цэгийн харагдах байдал, урдаас хойшоо чиглэлд

Зураг 04.Хуучин төвлөрсөн хогийн цэгийн төлөвлөлт



Зураг 05.Шинэ төвлөрсөн хогийн цэгийн төлөвлөлт

Метан хий зайлуулах хоолойны схем:



Хий зайлуулах хоолой ил гарах хэсгийг зурагт заасны дагуу шар, хар өнгөөр будна.

Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай машин, техникийн шаардлага:

№	Машин техникийн нэр	Зориулалт	Шаардлагатай тоо хэмжээ
	Бульдозер	Хог хаягдлыг түрэх, хөрсөөр хучих	
	Гинжит экскаватор	Ухлаг хийх, хучилтын хөрс бэлтгэх, ачааны автомашинд хөрс ачих	
	Задгай тэвштэй хүнд даацын ачааны автомашин	Хог хаягдлыг богино зайд тээвэрлэх, хучилтын хөрс тээвэрлэх	
	Ковш /50/	Тархсан хог хаягдлыг түрэх, хог хаягдал болон бэлтгэсэн хөрсийг ачааны автомашинд ачих	
	Автогреайдр	Хучилтын хөрсийг тэгшлэх, засах, шинэ талбайн улыг бэлтгэх	

Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай инженер, техникийн ажилтны шаардлага:

№	Албан тушаал	Мэргэжил	Чиг үүрэг	Шаардлагатай хүний тоо
	Автоинженер	Механик инженер	Техникин аюлгүй байдал, засвар үйлчилгээ, бүрэн бүтэн байдал	
	ХАБ-ын инженер	Инженер	Ажилчдын аюулгүй байдал	
	Талбайн инженер	Мэргэжил шаардахгүй		
	Жолооч	С ангилалтай	Ачааны машин жолоодох	
	Оператор	М ангилалтай	Бульдозер, автогрейдр, ковш, экскаватор	
	Туслах ажилтан	Мэргэжил шаардахгүй	Хог цэвэрлэгээ, түүвэр, бусад туслах ажил	

БОЛОВСРУУЛСАН:

БАЯН-ӨЛГИЙН АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН М.МАРИНА

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ӨЛГИЙ СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН
ЦЭГИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗУРАГ ТӨСӨЛ, АРГА ЗҮЙ
БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗӨВЛӨХ БАГИЙН АХЛАГЧ

С.АРИГУУН

ХЯНАСАН:

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН Т.АРИУНЦЭЦЭГ